



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 15 өдөр

Дугаар 4/03

Мандалговь

2020 оны цэргийн бүртгэл явуулах  
тухай

Монгол Улсын “Цэргийн албаны тухай хууль”-ийн 4.4 дүгээр зүйл, 34 дүгээр зүйл, Батлан хамгаалахын сайдын 2017 оны А/322 тоот тушаалаар батлагдсан “Цэргийн тоо бүртгэл зохион байгуулах журам”-ыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. 2020 оны Цэргийн бүртгэл явуулах аймгийн комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Комиссын дарга: Ц.Эрдэнэсүрэн (Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга)  
Орлогч дарга: Ш.Гансүх (Цэргийн штабын дарга, дэд хурандаа)  
Нарийн бичгийн дарга: Г.Цэрэндолгор (Цэргийн штабын тоо бүртгэлийн офицер, дэд хурандаа)  
Гишүүд: Ц.Баттулга (Цэргийн штабын орон нутгийн хамгаалалт, сургалтын офицер, дэд хурандаа)  
Сумдын Засаг дарга нар

Хоёр. Аймгийн цэргийн алба хаах насны болон цэргийн бэлтгэл алба хаах насны иргэдийн цэргийн бүртгэлийг 2020 оны 1 дүгээр сарын 20-наас 2 дугаар сарын 5-ны дотор зохион байгуулж явуулахыг аймгийн комиссын дарга (Ц.Эрдэнэсүрэн), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

Гурав. Сум, багуудад цэргийн бүртгэлийн ажлыг хүн ам, барилга, орон сууцны тоо бүртгэлтэй нягт уялдуулан зохион байгуулж гишүүдийн ажил үүргийн хуваарийг тогтоон, бүртгэл явуулахад шаардлагатай автомашин, ажлын байр, хүн хүчийг гарган ажиллуулсугай.

Дөрөв. Сумдад цэргийн бүртгэл хэрхэн явагдаж байгаад хяналт, үнэлгээ, шинжилгээ хийхэд зориулж цэргийн тоо бүртгэлийн комисст суудлын автомашинаар үйлчлэхийг комиссын дарга (Ц.Эрдэнэсүрэн)-д зөвшөөрсүгэй.

Тав. Сумдын Засаг дарга нарт даалгах нь:

1. Монгол Улсын Дайчилгааны тухай хууль, Батлан хамгаалах тухай хууль, Цэргийн албаны тухай хуулиудад заагдсан “Улсын дайчилгааны төлөвлөгөө” болон “Зэвсэгт хүчний анги байгууллагыг хүн хүч техникээр хангах төлөвлөгөө”-ний дагуу сумын хуулийн этгээдүүдийн улсын дайчилгааны даалгавар (хүнс болон эд хэрэгслийн тооцоо) цэргийн дайчилгааны даалгаварт оногдуулан данслагдсан бэлтгэл үүрэгтэй иргэд, авто техник, өөрөө явагч хэрэгсэл, ангийн буу зэргийг нэг бүрчлэн бүртгэн тоолж даалгаваржуулах;

2. Цэргийн тоо бүртгэлийн мэдээ, тайлангуудыг 2020 оны 2 дугаар сарын 6-ны өдөр Монгол Улсын “Төрийн болон албаны нууцын тухай хууль” Засгийн газрын 2017 оны 246 дугаар журмын дагуу нууцлан дэвтэрлэн (эхийг файлаар авчрах) авчрах;

3. Бүртгэлийг зохион байгуулахтай холбогдуулан иргэд, цэргийн үүрэгтнүүдэд 2016 онд шинэчлэн батлагдсан “Батлан хамгаалах”-ын багц хууль,

482010006

2018 онд батлагдсан “Орон нутгийн хамгаалалтын тухай хууль” Засгийн газрын 2018 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Цэргийн албыг биеэр хаах журам” мөн тус оны Засгийн газрын 11 дүгээр тогтоолоор батлагдсан “Цэргийн гэрээт алба хаах журам” зэрэг бусад холбогдох хууль, эрх зүйн баримт бичгүүдийн тухай, цэргийн жинхэнэ алба хаах тухай хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, тайлбарлан таниулах ажлыг шуурхай зохион байгуулан тайланг Цэргийн штабт ирүүлэх;

4. Цэргийн бүртгэлийн зөрчилтэй болон зайлсхийгчид, завсардагчид, урд онуудын нэг, хоёрдугаар ээлжийн цэрэг татлагад хамрагдаагүй цэргийн үүрэгтэнг эрэн сурвалжлах, бүртгэлд хамруулах ажилд Цагдаагийн байгууллага, иргэний бүртгэл мэдээллийн ажилтнууд болон холбогдох албан тушаалтнуудыг татан оролцуулах, тоо бүртгэлийн журам зөрчигчдөд “Цэргийн албаны тухай” хуулийн 11 дүгээр бүлгийн 36 дахь заалтын дагуу хариуцлага хүлээлгэж хэнд, ямар арга хэмжээ авсан тухай тайланг Цэргийн штабт ирүүлэх.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ